



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

200.0 оны 08 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 532

Улаанбаатар хот

Захирамжинд нэмэлт өөрчлөлт оруулж,  
дүрэм батлах тухай

Нэг. Нийслэлийн Засаг даргын 1999 оны А/209 тоот захирамжийн 1 дүгээр заалтанд "...төсөвт үйлдворийн газар" гэснийг "...төсөвт байгууллага", 4 дүгээр заалтанд "...нийслэлийн Ахмадын хороонд" гэснийг "...нийслэлийн Ахмадын өргөөнд", 5 дугаар заалтанд "...Нийслэлийн Соёлын төв өргөөтэй түрээсийн гэрээ, Ахмадын хороотой Өмч эзэмшлийн гэрээ байгуулсугай" гэснийг "...Нийслэлийн Соёлын төв өргөө", "...Нийслэлийн ахмадын өргөөтэй" Өмч эзэмшлийн гэрээ байгуулсугай" гэж өөрчлөн найруулсугай.

Хоёр. "Нийслэлийн Соёлын төв өргөө"-ний дүрмийг 1 дүгээр хавсралтаар, орон тоо бутцийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. "Нийслэлийн Соёлын төв өргөө"-ний жил бүрийн соёлын үйл ажиллагааны зорилт, төсвийг хянан баталж байхыг Санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/, Өмчийн газар /Б.Буянмөнх/, Соёлын газар /Г.Нямсамбуу/-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Жил бүрийн төсвийн төлөвлөгөөнд батлагдсан түрээсийн орлогыг Өмчийн газарт төвлөрүүлэхийг "Нийслэлийн Соёлын төв өргөө" /Б.Байгалмаа/-нд даалгасугай.

Тав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1999 оны А/209 тоот захирамжийн 3 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2000 оны  
...~~6.3.2~~ тоот захирамжийн 1 дүгээр  
хавсралт

## “НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨ”-НИЙ ДҮРЭМ

### **Нэг. Еронхий үндэслэл**

1.1. “Нийслэлийн Соёлын төв өргөө” нь /цаашид “өргөө” гэх/ нийслэлийн иргэдэд соёл урлагаар үйлчлэх үндсэн үүрэгтэй, нийслэлийн өмчийн байрны ашиглалт, үйлчилгээг хариуцаж ажиллах чиг үүрэг бүхий төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх нийслэлийн Засаг даргын дэргэдэх Соёлын газрын харьяаллын төсөвт байгууллага мөн.

1.2. “Өргөө” нь үйл ажиллагаанд Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Өмчийн болон Соёлын газрын даргын тушаал, шийдвэрийг удирдлага болгоно.

1.3. “Өргөө” нь соёл урлагийн арга хэмжээ зохиох, эзэмшилдээ байгаа нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд түрээслүүлэх үйл ажиллагаа явуулна.

1.4. “Өргөө”-г татан буулгах, ерөнхий захирлыг томилох, чөлөөлөх, дүрэм, зохион байгуулалт, орон тоо, бүтцийг батлах асуудлыг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Соёлын газар, Өмчийн газар, Санхүүгийн хэлтсийн саналыг авч нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

1.5. “Өргөө” нь зохих журмын дагуу хийгдсэн тамга, тэмдэг, албан бичгийн болон тушаалын хэвлэмэл хуудас, үзвэрийн билет, урилга хэрэглэнэ. Банкинд харилцах данстай байна.

### **Хоёр. Захирлын эрх үүрэг.**

2.1. “Өргөө”-ний өдөр тутмын үйл ажиллагааг ерөнхий захирал удирдан явуулна.

2.2. “Өргөө”-ний захирал нь Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал таргана.

2.3. Батлагдсан орон тоо, цалингийн санд багтаан ажиллагсдыг ажилд томилох, чөлөөлөх, байгууллагын дотоод журам батлах зэрэг асуудлыг ерөнхий захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

2.4. Захирлын дэргэд зөвлөл байгуулан ажиллуулж болох ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Соёлын газартай зөвшилцсөний үндсэн дээр ерөнхий захирал батлана.

## Гурав. “Нийслэлийн Соёлын төв өргөө”-ний эрх, үүрэг

### А. “Өргөө”-ний эрх.

3.1. “Өргөө” нь үйлчилгээний орлогоо төсвийн орлогоор, зарлагаа төсвийн зарлагаар тооцож, төсөвт байгууллагын няглан бодох бүртгэл хөтлөн тайлан тэнцэл гаргана.

3.2. “Өргөө” нь жилийн орлого, зарлагын төсвөө нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хэлтсээр хянуулан батлуулж, улирал жилийн тайлан тэнцлээ “Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн” дагуу баталгаажуулж ажиллана.

3.3. “Өргөө” нь нийслэлийн Өмчийн газартай өмч эзэмшлийн гэрээ байгуулж ажиллах бөгөөд түрээсийн гэрээ, түрээсийн орлогоо Өмчийн газраар хянуулж батлуулна.

3.4. “Өргөө” нь соёл урлагийн үйл ажиллагааны тухай Соёлын газарт тайлагнана.

3.5. “Өргөө”- нь эзэмшиж байгаа нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцах.

3.6. Эзэмшиж буй барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, ашиглалтыг сайжруулан үр ашгийг дээшлүүлэх.

3.7. Нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, үзвэрийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс тавьсан асуудлыг хүлээн авч шийдвэрлэх.

3.8. Эзэмшиж буй барилга байгууламж, эд хөрөнгийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээд зориулалтын дагуу түрээслүүлэх, соёл урлагийн арга хэмжээнд төлбөртэй ашиглуулах.

а/ Түрээсийн болон үзвэрийн орлогын шимтгэлийн гэрээг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн боловсруулсан загвараар байгуулж, мөрдөн ажиллах.

б/ Түрээсийн болон үзвэрийн орлогын шимтгэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх, төлбөр тооцоог цаг хугацаанд нь барагдуулж байх.

в/ Барилга байгууламж, эд хөрөнгийн түрээсийн болон үзвэрийн орлогын шимтгэлийн үнийг мөнгөний ханшины өөрчлөлттэй уялдуулан холбогдох байгууллагуудтай зөвшилцсений дагуу өөрчилж, шинэчлэн тогтоох.

3.9. Санхүү, аж ахуй, соёлын үйлчилгээний сар, улирал, жилийн тайлан, цаг үеийн мэдээг харьяалах холбогдох байгууллагуудад хугацаанд нь гаргаж өгч байх.

## Б/ "Өргөө"-ний эрх

4.1. Барилга байгууламж, эд хөрөнгийг түрээслэгч, үзвэр үйлчилгээ явуулах байгууллага, иргэдийг сонгох, түрээсийн гэрээ байгуулах, хууль тогтоомж болон гэрээний үүргээ биелүүлэгэй түрээслэгч, үзвэр үйлчилгээ явуулагчдын байгуулсан гэрээг цуцлах, гэрээний хариуцлага тооцох.

4.2. Гадаад дотоодын байгууллага, иргэдтэй харилцах, ажил төрлийн холбоо тогтоох.

4.3. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу ажиллагсдынхаа ажиллах нөхцөл бололцоог хангах, шагнал урамшил /үр дүнгийн шагнал/, тэтгэвэр тэтгэмж олгох асуудлыг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэх.

Бусад зүйл.

Нийслэлийн Засаг даргын 2000 оны  
Б.З.Х. тоот захирамжийн 2 дугаар  
хавсралт

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ  
ОРОН ТОО, БҮТЭЦ**

Албан тушаалын нэр	Орон тоо
<b>Нэг. Захиргаа аж ахуйн алба</b>	
Захирал	1
Ерөнхий инженер	1
Эрхлэгч оператор /бичиг хэрэг, гадаад харилцаа, зохион байгуулалт хариуцсан захирлын туслах	1
Ерөнхий ня-бо	1
Аж ахуйн дарга	1
Тооцооны ня-бо	1
Нярав	2
Суудлын машины жолооч	1
Автобусны жолооч	1
Ээлжийн жижүүр	8
<b>Дүн</b>	<b>18</b>
<b>Хоёр. Соёл урлаг, гэрэл тайз, холбооны алба</b>	
Ерөнхий менежер	1
Уран сайхны удирдагч, найруулагч	1
Инженер	1
Гэрэл дууны техникийн засварчин	1
Гэрлийн оператор	1
Дууны оператор	1
АТС-ийн техникч	1
Тайзны машинч-механикч	2
Тайзны оператор	1
Гэрэлтуулэгч	5
<b>ДҮН</b>	<b>14</b>
<b>Гурав. Дулаан, сантехник, цахилгаан, барилга засварын анги</b>	
Дулааны инженер	1
Дулааны тоног төхөөрөмжийн дисплетчер	8
Дулааны тоног төхөөрөмжийн слесарь	1
КИП-автоматик техникч	1
Бохир усны төхөөрөмжийн слесарь	2
Гагнуурчин	1
Цахилгааны инженер	1
Цахилгаанчин	4
Лифтчин	3
Дархан	1
Барилгын засварчин	2
<b>ДҮН</b>	<b>25</b>

**Дөрөв.Зохион байгуулах анги**

Зохион байгуулах ангийн дарга	1
Билет худалдагч	1
Зохион байгуулагч, цэцэгчин	1
Тайлбайн үйлчлэгч	20
<b>ДҮН</b>	<b>23</b>

**Тав.Соёл-Эрдэнэ хамтлаг**

Уран сайхны удирдагч	1
Дуучин	1
Хөгжимчин	1
<b>ДҮН</b>	<b>4</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>6</b>
	<b>86</b>